



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 432

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх ажлын удирдамжийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д үүрэг болгосугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081526

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 10 сарын 28 өдрийн
432 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



Ажлын удирдамж

Зорилго:

2006-2015 онд хэрэгжүүлэх “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээ хийж, санал зөвлөмж боловсруулахад оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

- Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэнэ.
- Дунд хугацааны үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг тооцно.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүжилтыг тооцно.
- Шалгуур үзүүлэлтийн биелэлт, хүрсэн түвшин, үр дүнд дүгнэлт хийнэ.
- Хөтөлбөрийн зорилт тус бүрээр ололт амжилт, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон үр дүнг тооцож, шийдвэрлэх асуудал, хэрэгжүүлэх арга замыг тусгасан тодорхой зөвлөмжүүд дэвшүүлнэ.
- Хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эсэх талаар үндэслэл бүхий санал дэвшүүлнэ.
- Үнэлгээний тайланг эцэслэн ЭМСЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.
- Үнэлгээний дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулна.


Хугацаа:

2015 оны 11 дүгээр сарын 2-ны өдрөөс 12 дугаар сарын 2-ны өдрийг дуустал

Хүрэх үр дүн:

- Хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж, санал зөвлөмж дэвшүүлсэн байна.
- Хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эсэх асуудлыг Удирдлагын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлсэн байна.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 10 сарын 28 өдрийн
432 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ахлагч:

Э.Оюунсүрэн, Эрүүл мэнд, спортын яамны
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Б.Хонгорзул, Эрүүл мэнд, спортын яамны
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын мэргэжилтэн

Ш.Уранцэцэг, Эрүүл мэнд, спортын яамны
Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн Орчны
эрүүл мэндийн бодлогын хэрэгжилт
хариуцсан мэргэжилтэн

Ц.Хандармаа, Эрүүл мэнд, спортын яамны
Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн Химийн
бодисын аюулгүй байдлын бодлогын
хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

С.Өнөрсайхан, Нийгмийн эрүүл мэндийн
үндэсний төвийн Орчны эрүүл мэнд, хор
судлалын төвийн дарга

Б.Баясгалан, Мэргэжлийн хяналтын
ерөнхий газрын Эрүүл ахуй, халдвар
хамгааллын хяналтын улсын ахлах
байцаагч (зөвшилцсөнөөр)